



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

### XIV ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын XIV хурал 2020 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 14:00 цагаас Төрийн ордон дахь Монгол Улсын Шадар сайдын ажлын өрөөнд 96 хувийн ирцтэйгээр хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Ө.Энхтүвшин даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

#### ХЭЛЭЛЦСЭН нь:

1. Монгол Улсын иргэдийг гадаад улс орноос захиалгат нислэгээр татан авчрах тухай Зам, тээврийн хөгжлийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан;
2. Шинэ коронавируст халдварын нөхцөл байдлын талаар Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл нарын мэдээллийг сонсов.

#### ШИЙДВЭРЛЭСЭН нь:

А. Олон улсын нислэгийг түр зогсоосонтой холбогдуулан эх орондоо яаралтай ирэх хүсэлт гаргасан, хүндэтгэн үзэх шалтгаантай Монгол Улсын иргэдийг Улаанбаатар - Токио - Улаанбаатар, Улаанбаатар - Сөүл - Улаанбаатар чиглэлийн захиалгат нислэгээр татан авчрах ажлыг зохион байгуулах;

Б. Шинэ коронавируст халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах хяналтыг сайжруулах зорилгоор халдварын голомт бүхий гадаад улс орнуудаас захиалгат нислэгээр ирсэн иргэдийг тусгаарлах байранд ажиглах хугацааг 21 хоног болгож сунгахаар тус тус шийдвэрлэв.

Нэг. Зам, тээврийн хөгжлийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан,  
Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар,  
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Т.Бадрал,  
Хил хамгаалах ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасүрэн,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү нарт:

1.1. Эх орондоо ирэх хүсэлт гаргасан хүндэтгэн үзэх шалтгаантай Монгол Улсын иргэдийг захиалгат нислэгээр татан авчрах ажлын бэлтгэлийг сайтар хангах, хяналтыг чангатгах, холбогдох мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулах, зохион байгуулалтын бусад арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх;

1.2. Гадаад улс орнуудаас Монгол Улсын иргэдийг татан авчрах захиалгат нислэгийг зөвхөн олон улсын хуваарьт нислэг гүйцэтгэдэг орнууд руу үйлдэх, дараа дараагийн захиалгат нислэгийн хуваарийг Улсын онцгой комиссын Шуурхай штаб дээр боловсруулан, Улсын онцгой комиссын даргаар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

1.3. Шинэ коронавируст халдварын цар тахал зогсож, олон улсын нислэгүүд болон төмөр замын зорчигч тээвэр хэвийн горимд шилжих хүртэлх хугацаанд зайлшгүй шаардлагаар гадаад оронд зорчсон Монгол Улсын иргэдэд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдал цуцлагдах хүртэлх хугацаанд ирэхгүй байх талаар анхааруулж, холбогдох арга хэмжээ авах;

Хоёр. Эрүүл мэндийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,  
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Т.Бадрал,  
Цагдаагийн ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал С.Баатаржав,  
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү,  
Аймаг нийслэлийн Засаг дарга,  
Онцгой комиссын дарга нарт:

2.1. Гадаад улс орноос ирэх иргэдийг тусгаарлах байранд ажиглалт хийх хугацааг 21 өдөр болгож сунгасан тул тусгаарлалттай холбоотой зардлыг тухайн иргэн өөрөө хариуцах, энэ хугацаанд 3 удаа шаардлагатай хувийн хэрэглээний зүйлс, ном, сэтгүүл, эм бэлдмэл (халуун бууруулах, өвчин намдаах зориулалт бүхий эмийг хориглоно)-ийг хүргүүлж авах боломжийг бүрдүүлэх;

2.2. Монгол Улсын хилийн автозамын боомтоор орж ирсэн иргэдийг тусгаарлах байранд ажиглах хугацааг 14 хоног хэвээр мөрдөх, 2020 оны 3 дугаар сарын 26-ны өдрөөс өмнө захиалгат нислэгээр ирсэн иргэдийг тусгаарлах байранд ажиглах хугацааг сунгасан нэмэлт 7 хоногийн зардлын санхүүжилтийн асуудлыг судлан санал боловсруулж, Засгийн газарт танилцуулж шийдвэрлүүлэх;

2.3. Шинэ коронавируст халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, тусгаарлах байранд ажиглалтад хамрагдах иргэдийн эрүүл мэндийг болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор тусгаарлах байрны 1 өрөөнд 1 хүн (1 гэр бүл)-ийг байршуулах боломжийг судлан, холбогдох арга хэмжээ авах;

2.4. Гадаад улс орнуудаас Монгол Улсын иргэдийг захиалгат нислэгээр татан авчрах үед дараахь зөвлөмжийг чанд мөрдөн хэрэгжүүлж ажиллах. Үүнд:

2.4.1. Гадаад улс орноос Монгол Улс руу зорчих иргэд шинэ коронавируст халдварын шинжилгээнд хамрагдан, шинжилгээний хариу сөрөг гарсаныг нотлох эмнэлэгийн баримт бичигтэй байх;

2.4.2. Шинэ коронавируст халдварын шинжилгээнд хүндэтгэн үзэх шалтгаанаар хамрагдаж чадаагүй иргэнд түргэвчилсэн оношлуурыг ашиглан шинжилгээ хийх, бүх иргэдэд эрүүл мэндийн анхан шатны үзлэг хийх 2 эмчийг томилон ажиллуулах;

2.4.3. Халуурах, ханиалгах, толгой өвдөх, бие ядарч сульдах, хоолой өвдөх, бөөлжих, суулгах шинж тэмдэг бүхий иргэнийг тухайн орны эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэх;

2.4.4. Онгоцонд суух зорчигчдод шинэ амны хаалт, нэг удаагийн бээлийтэй байх шаардлага тавих;

2.4.5. Нислэгийн хугацаанд зорчигчид хоорондоо харилцахгүй байхыг анхааруулах, биеийн халууныг 2 цаг тутамд хэмжиж, сэжигтэй тохиолдол илэрсэн үед арын эгнээнд тусгаарлах;

Гурав. Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатарт:

3.1. Монгол Улс руу захиалгат нислэгээр ирэх иргэдийг нислэг үйлдэх гадаад улсын нисэх онгоцны буудлын ойролцоо байршилд эрүүл мэндийн үзлэгт хамруулах боломжийг бүрдүүлэх, дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах хүсэлтийг тухайн улсын эрх бүхий байгууллагад тавьж, шийдвэрлүүлэх, холбогдох арга хэмжээ авч ажиллах;

Дөрөв. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумьяабазар,  
Зам, тээврийн хөгжлийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан,  
Хил хамгаалах ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасүрэн,  
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү  
нарт:

4.1. Монгол Улсын хилийн боомтоор уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлох, тээвэрлэх бэлэн байдлын шалгалтын дүнг 2020 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн дотор Улсын онцгой комиссын даргад танилцуулж, хилийн боомтоор уул уурхайн

бүтээгдэхүүнийг экспортлох, тээвэрлэх ажлыг эрчимжүүлэх, тээврийн хэрэгслийн жолооч нарын эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах бүх нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг тус тус үүрэг болгов.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,  
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА



Ө.ЭНХТҮВШИН

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,  
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ТЭРГҮҮН ДЭД ДАРГА,  
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

A handwritten signature in black ink, appearing to read "Г.Ариунбуян".

Г.АРИУНБУЯН